

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 ОНЫ 7-Р САРЫН 6 ӨДӨР

УЛААНБААТАР

## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1/19 1

19 1 дүгээр зүйл. Эрдэм шинжилгээний байгууллагын ил тод байдал

19 1 .1. Үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санд судалгаа хөгжүүлэлт, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээний мэдээллийг байршуулж, ил тод, аюулгүй байдлыг Засгийн газар хариуцна.

19 1 .2. Үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санд судалгаа хөгжүүлэлт, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээний мэдээллийг байршуулж, ил тод, аюулгүй байдлыг Засгийн газар хариуцна.

19 1 .3. Эрдэм шинжилгээний байгууллага нь дараах мэдээллийг хуулиар нууцлахыг хориглосноос бусад тохиолдолд үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санд байршуулж, ил тод байлгана:

19 1 .3.1. энэ хуулийн 3.1.7, 3.1.8, 3.1.9, 3.1.10, 3.1.11- д заасан эрдэм шинжилгээний ажлын тайлан;

19 1 .3.2. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийсэн судалгаа, хөгжүүлэлтийн ажлын тайлан;

19 1 .3.3. тухайн байгууллагын судлаач, эрдэм шинжилгээний ажилтны эрдэм шинжилгээний бүтээлийг өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн;

19 1 .3.4. хуульд заасан бусад.

2/23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг:

“23.4. Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарласан сонгон шалгаруулалтад энэ хуулийн 3.1.11-т заасан

судалгааны үндсэн чиглэлээр шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт зүгшрүүлэлтийн ажлыг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх тохиолдолд тендерийн болон гүйцэтгэлийн баталгаанаас чөлөөлнө.”

3/23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг:

“23.5. Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсан сонгон шалгаруулалтад оролцож бий болгосон бүтээлийг хуулиар нууцлахыг хориглосноос бусад тохиолдолд эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн санд байршуулна.”

2 дугаар зүйл.. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“18.2.2. Дээд боловсролын тухай хуулийн 4.1.4-т заасан судалгааны их сургууль;”

3 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн “Үндэсний хорооны тогтоол, зөвлөмжийг үндэслэн” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.